

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН  
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**/Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн  
шинэчилсэн найруулгын тесел/**

Нэг. Ерөнхий мэдээлэл

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тесел батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон өргөжиж байгаа үргийн улмаас бий болох зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”/цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог хийнэ.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тесел батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, түүнийг хялбарчлах болон бууруулах талаар санал боловсруулах, хуулийн төслийн зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү тайлангийн зорилго орших юм.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн тесел нь хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах, хуульчид тавигдах шаардлагыг тодорхойлох, хуульчийн эрх зүйн байдлыг тогтоох, хуульч бэлтгэх сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн байдалтай холбоотой харилцааг зохицуулах үндсэн зорилготой юм.

Өөрөөр хэлбэл хуулийн тесел нь иргэн хуульчийн мэргэжлийн шалгалт өгөх, уг шалгалтанд тэнцсэн этгээдэд тавигдах шаардлагыг тогтоох болон тэдгээр иргэдийн эрх ашгийг нэгдэл болсон төрийн бус мэргэжлийн байгууллагын эрх зүйн байдлыг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулах юм.

Иймд хуулийн төслийн онцлог нь төрийн аль нэг байгууллагад оногдуулсан, тухайн байгууллага байнга гүйцэтгэх чиг үүрэг байхгүй бөгөөд Хуульчдын холбооны болон хуульчийн эрх зүйн байдлыг тогтоосон байна.

Иймд хуулийн тесел нь төрд зардал үүсгэхгүй бөгөөд хуулийн этгээд буюу Хуульчдын холбооны одоо хэрэгжүүлж байгаа чиг үүргийг нэмэгдүүлээгүй байх тул зардал үүсгэхгүй, зөвхөн иргэн хуульчийн мэргэжлийн шалгалт өгөх үүрэгтэй холбоотой зардал үүсэхээр байна.

Хуулийн төслийн зохицуулалтаар хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцох этгээдийг өргөжүүлсэн буюу Нотариатын тухай хуульд 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орж нотариатч нь хуульч байх шаардлагатай


<sup>1</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

болсон болон эрх зүйч мэргэжлийн дадлага хийсэнд тооцох ажил, албан тушаалыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор иргэн хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцох үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэх зардлыг тооцоолох юм.

### ХОЁРХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИИГ ДАГАЛДАН ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО


Энэхүү тооцооны аргачлалаар иргэн хуулийн төсөлд заасны дагуу хуульчийн мэргэжлийн шалгалт өгөхтэй холбоотойгоор тухайн иргэнд үүсэх мөнгөн зардал болон зарцуулах цаг хугацааг тооцоолно.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:



#### 2.1. ИРГЭНИЙ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:

Иргэний гүйцэтгэх үүргийг тодорхойлохын тулд дараах алхмыг зайлшгүй хийнэ.



- Хууль тогтоомжийн төсөлд тусгагдсан иргэний гүйцэтгэх үүргийг нэг бүрчлэн тодорхойлно;
- Тодорхойлсон үүргийн агуулга нэг бүрийг тодорхойлно.

6

**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг  
хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайлан**

• Энэхүү гүйцэтгэх үүрэг гэдэгт тухайн иргэнд холбогдох мэдээллийг төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд бэлтгэж өгөх, бэлэн байлгах, эсвэл мэдээлэл хүргүүлэх, холбогдох үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах үүргийг хууль тогтоомжоор оногдуулсан байхыг ойлгоо заасан тул Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 10 дугаар зүйлд заасан хуульчийн шалгалтад оролцох өргөдөл гаргах үүргийг хуушиар хүлээлгэсэн тул зардлыг нь тооцоолох ёстой гэж үзэж, түүнийг хэрэгжүүлэхийн тулд иргэнээс зарцуулах цаг хугацаа, нэмэлт зардлыг тооцоюү.

Доорх хүснэгтээр иргэний гүйцэтгэх үүрэг болон үүргийн агуулгыг тогтооё. Үүргийн агуулга гэдэгт тухайн үүргийг гүйцэтгэх иргэнээс хууль тогтоомжоор шаардаж буй баримт бичгийн болон үйлдлийн бүрдлийг ойлгох юм.

Хүснэгт 1

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга <sup>2</sup>	Тайлбар
1	10.1.Энэ хуулийн 8.1-д заасан шаардлагыг хангасан хүн хуульчийн шалгалтад орох тухай өргөдлөө Шалгалтын комисст гаргана. 10.2.Хуульчийн шалгалтад орох тухай өргөдөлд доор дурдсан баримт бичгийг хавсаргана.	10.2.1.Монгол Улсын иргэний үнэмлэх, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний хувьд паспорт болон түүнийг орлох баримт бичгийн хуулбар 10.2.2.эрх зүйч мэргэжлийн боловсролын дипломны хуулбар 10.2.3.мэргэжлийн дадлага хийснийг нотлох баримт бичиг 10.2.4.Хуульчдын холбоноос баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл гаргагчийн мэдээлэл 10.2.5.сэтгэцийн эмгэггүйг нотолсон тодорхойлолт	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 10 дугаар зүйлд хуульчийн мэргэжлийн шалгалт өгөх иргэнээс шаардах баримт бичгийн бүрдлийг шууд нэрлэн зааснаас эшлэв.

<sup>2</sup> Үүргийн агуулгыг хуулийн төсөлд шууд заасан өгсөн буюу 10.2 дахь хэсгээр шалгалтад орох өргөдөл гаргагчаас шаардах баримт бичгийн бүрдлийг зааж өгсөн тул агуулгыг хуулийн төсөлд тусгагдснаар тодорхойлсон болно.

## 2.2. Зарцуулах хугацаа болон гарч болох зардлыг тооцох

Энэ үе шат буюу тухайн үүргийг гүйцэтгэхэд нэг иргэний зарцуулах хугацаа болон зардал, ачааллыг тооцох бөгөөд дараах алхмын дагуу гүйцэтгэнэ;



- Үүргийг гүйцэтгэхэд иргэнээс зайлшгүй хийгдэх үйл ажиллагааг нэг бүрчлэн тодорхойлох;
- Үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацааг тооцож гаргах. Түүнчлэн үүргийг хэрэгжүүлэхэд гарах мөнгөн зардлыг

мөн тооцно;

- Хуулийн төслөөр иргэний хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэх үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн хугацаа нь иргэн бурийн хувьд харилцан адилгүй байж болох боловч тухайн хуулийн үйлчлэлд хамаарах иргэдийн онцлог, хүлээж буй үүргийн төрөл, нийгмийн байдал зэргээс хамааран цаг хугацааг ердийн дундаж иргэний гүйцэтгэх хугацаагаар баримжаалан доорх байдлаар тооцов.

Хүснэгт 2

Д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
1	10.1. Энэ хуулийн 8.1-д заасан шаардлагыг хангасан хүн хуульчийн шалгалтад орох тухай өргөдлөө Шалгалтын комисст гаргана.	10.2.1. Монгол Улсын иргэний үнэмлэх, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний хувьд паспорт болон түүнийг орлох баримт бичгийн хуулбар	Баримт бичгийн эх хувиас хуулбар хийх;	5 мин
		10.2.2. эрх зүйч мэргэжлийн боловсролын дипломын хуулбар	Боловсролын дипломыг хуулбарлах;	5 мин
		10.2.3. мэргэжлийн дадлага хийснийг нотлох баримт бичиг	Ажил олгогчоос мэргэжлийн дадлагад хамаарах ажлын байранд ажилласныг нотлох баримт авах тухай хүсэлт гаргах;	15 мин
		10.2.4. Хуульчдын холбооноос баталсан маягтын дагуу гаргасан	Ажил олгогчоос олгосон мэргэжлийн дадлага хийсэн талаарх баримтыг өргөдөл хавсаргах;	5 мин
			Баталсан маягтын дагуу шалгалтанд оролцуулах тухай өргөдөл гаргах;	15 мин

**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг  
хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайлан**

		өргөдөл мэдээлэл	гаргагчийн мэдээллийг нягтлах;	Маягтад бөглөсөн 5 мин
		10.2.5.сэтгэцийн эмгэггүйг нотолсон тодорхойлолт	Cэтгэцийн эмчид үзүүлэх; Сэтгэцийн эмчийн тодорхойлолт гаргуулах.	20 мин 10 мин
2	<b>НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА</b>			<b>80 мин</b>

**• Мөнгөн зардлыг тооцох:** Мөнгөн зардал гэдэгт тухайн үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс зайлшгүй гарах мөнгөн зардал нь бодит буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон зардлыг ойлгоно. Үүнд: мэдээллийг холбогдох газарт хүргүүлэхэд гарах бичиг хэрэг, шуудангийн зардал, баримт бичгийг нотариатаар баталгаажуулахыг шаардсан тохиолдолд нотариатын зардал, гадаад паспорт авах өргөдөл гаргахад цээж зураг авахуулах зардал, зөвшөөрөл хүсэхэд төлөх хураамж зэргийг оруулна.

Манай тохиолдолд хуульчийн мэргэжлийн шалгалт өгөхэд иргэнийг шалгалтын хураамж төлөхийг шаарддаг бөгөөд мөн бусад баримт бичиг олшруулахтай холбоотой дараах мөнгөн зардал үүсэхээр байна.

Харин үүргийг хэрэгжүүлэхэд тухайн иргэнээс гарч болох замын зардлыг тооцохгүй байхыг аргачлалд заасан тул замын зардлыг тооцохгүй юм.

Хүснэгт 3


д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Мөнгөн зардал байгаа эсэх, хэмжээ
1	10.1.Энэ хуулийн 8.1-д заасан шаардлагыг хангасан хүн хуульчийн шалгалтад орох тухай өргөдлөө Шалгалтын комисст гарана.	10.2.1.Монгол Улсын иргэний үнэмлэх, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний хувьд паспорт болон түүнийг орлох баримт бичгийн хүүлбар	Баримт бичгийн эх хувиас хуулбар хийх;	хуулбар хийхэд 100 төгрөг
		10.2.2.эрх зүйч мэргэжлийн боловсролын дипломыг хуулбарах;	Боловсролын дипломыг хуулбарлах;	хуулбар хийхэд 500 төгрөг
		10.2.3.мэргэжлийн дадлага хийснийг нотлох баримт бичиг	Ажил олгогчоос мэргэжлийн дадлагад хамаарах ажлын байранд ажилласныг нотлох баримт авах тухай хүсэлт гаргах;	байхгүй
			Ажил олгогчоос олгосон мэргэжлийн дадлага хийсэн талаарх баримтыг өргөдөлд хавсаргах;	байхгүй

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг  
хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайлан

		10.2.4.Хуульчдын холбооноос баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл гаргагчийн мэдээлэл	Баталсан маягтын дагуу шалгалтанд оролцуулах тухай өргөдөл бөглөх;	шалгалтын хураамж 50.000 төгрөг <sup>3</sup>
		10.2.5.сэтгэцийн эмгэггүйг нотолсон тодорхойлолт	Маягтад бөглөсөн мэдээллийг нягтлах;	байхгүй
			Сэтгэцийн эмчид взүүлэх;	байхгүй
2	<b>НИЙТ ЗАРЦУУЛАХ МӨНГОН ЗАРДАЛ</b>	<b>Сэтгэцийн эмчийн тодорхойлолт гаргуулах.</b>	<b>Байхгүй</b>	<b>50.600 төг</b>

### 2.3.Тоон үзүүлэлтийг тооцох

Энэ үе шатанд иргэнд хуулийн төслөөр хүлээгэсэн гүйцэтгэх үүргийг тухайн харилцаанд оролцогч хичнээн иргэн жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг хуанлийн нэг жилээр тооцож гаргана. Өөрөөр хэлбэл хуульчийн мэргэжлийн шалгалт өгөх үүргийг иргэн жилд хэдэн удаа гүйцэтгэх болон нийт хэдэн иргэн энэ үүргийг гүйцэтгэх ёстойг гаргах юм.



- Үүнийг буюу тоон үзүүлэлтийг тохиолдлын тоо, давтамжийн тоо гэсэн хоёр тооны үржвэрээр тодорхойлно.

**Тоон үзүүлэлт = Тохиолдлын тоо × Давтамжийн тоо**

• Тохиолдлын тоо гэдэг нь тухайн үүргийг хэдэн хүн гүйцэтгэх ёстой вэ буюу Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр иргэнд хүлээлгэсэн үүрэг буюу хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцох үүргийг хэдэн иргэн гүйцэтгэх ёстойг,

• Давтамжийн тоо гэдэг нь жилд тухайн үүргийг хэдэн удаа хийх ёстой вэ гэдгийг илэрхийлэх ойлголт юм.

<sup>3</sup> 2019 онд Монголын хуульчдын холбооноос зохион байгуулсан Хуульчийн мэргэжлийн шалгалтын бүртгэлийн хураамж 50.000 байсан болно.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг  
хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайлан

### Хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцогчийн тоон үзүүлэлт

Хүснэгт 4

д/д	Шалгалт зохион байгуулсан он	Шалгалтад оролцох хүсэлт гаргасан хүний тоо
1	2016 он	1325
2	2017 он	1083
3	2018 он	1247
4	2019 он	1243
5	Дундаж үзүүлэлт	1224

Дээрх нь Монголын хуульчдын холбооноос гаргасан албан ёсны тоо тул шууд эх сурвалж болгон ашиглаж болох бөгөөд сүүлийн 4 жилийн үзүүлэлтийг дундажлан тохиолдлын тоог тогтоов.

Харин Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зааснаар хуульчийн шалгалтад орж тэнцсэн этгээдэд Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хугацаагүй олгодог тул давтамж нь 1 байх юм.

**Тоон үзүүлэлт = Тохиолдлын тоо × Давтамжийн тоо**

**Тоон үзүүлэлт = 1224 тохиолдол x 1 давтамж = 1224 байна.**

### 2.4.НИЙТ ДҮНГ ТООЦОЖ ГАРГАХ

Хуулийн төслөөр хүлээсэн тухайн үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хуулийн төслийн үйлчлэл хамаарч байгаа нийт иргэдэд үүсэх цаг хугацааны ачааллыг тооцож гаргана. Үүнийг нэг иргэний зарцуулах цаг хугацааны зарцуулалтыг тоон үзүүлэлтээр үржүүлснээр тогтооно. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 10 дугаар зүйлд заасан иргэнд хүлээлгэж буй үүрэг нь уг хуулийн төслийн үйлчлэлд хамаарах нийт иргэдэд ямар хэмжээний цаг хугацааны ачаалал үүсгэж болохыг доор тооцвол:

**Хуулийн төслийн иргэдэд үзүүлж буй нийт цаг хугацааны ачаалал = 80 мин  
× 1224 = 97920 мин : 60 мин = 1632 цаг**

## 2.5.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ, ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙГ ИЛЭРХИЙЛЭХ ТАЛААР

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслөөр иргэнд хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцох үүргийг оногдуулсан бөгөөд шалгалтад оролцсх өргөдөл гаргах үүргийг хэрэгжүүлэхийн тулд нэг иргэн 80 минутын хугацаа зарцуулж, 50000 төгрөгийн шууд мөнгөн зардал гаргахаар өвина.

Хуулийн төсөлд иргэний бүрдүүлэх баримт бичгийг тодорхойлж өгсөн бөгөөд илүү буюу шаардлагагүй материал иргэнээс шаардаагүй байгааг дурдах нь зүйтэй. Бүртгэлийн хураамжид төлж буй зардлыг тухайн шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулахад зарцуулагддаг тул үүнийг бууруулах боломжгүй юм.

Иймд хуулийн төслөөр иргэний хүлээж буй үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой иргэнээс зарцуулж буй цаг хугацаа болон мөнгөн зардал нь хэвийн буюу хүлээн зөвшөөрч болохуйц хэмжээнд байна гэж үзлээ.

## ГУРАВДУГНЭЛТ

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан гарах зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2015 оны 59 дугээр тогтоопын 4 дугээр хавсралтаар баталсан аргачлалыг баримтлан гүйцэтгэв.

Хуулийн төслийн зохицуулалтаар хуулийн этгээд болон төрийн байгууллагад ямар нэг зардал үүсэхгүй бөгөөд харин хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шалгалтад оролцох иргэдийн нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор иргэнд тодорхой төрлийн зардал үүсгэнэ гэж үзэж зардлыг тооцов.

Хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцох үүрэг нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар байгаа боловч энэхүү үүргийг хэрэгжүүлэх этгээдийг хуулийн төслөөр өргөжүүлсэн буюу нотариатч нь хуульч байх шаардлагатай болсон болон эрх зүйч мэргэжлийн дадлага хийсэнд тооцох ажил, албан тушаалыг одоо байгаагаас нэмэгдүүлснээс гална уг үүргийг жил бүр шинэ хүмүүс хүлээдэг тул үүсэх зардлыг тооцоолсон болно.

Иргэнд үүсэх зардлыг тухайн үүргийг хэрэгжүүлэхэд иргэний зүгээс зарцуулах цаг хугацаагаар тооцон гаргахаар аргачлалд заасан тул цаг хугацааны зарцуулалтыг гаргасан болно. Харин тухайн үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой иргэн бүрээс нийтлэг байдлаар заавал гаргахаар заасан мөнгөн зардлыг тооцохыг аргачлалд заасан тул хуульчийн мэргэжлийн шалгалт өгөхтэй холбоотой үүсэх мөнгөн зардлыг мөн тооцоолсон болно. Хуулийн төслийн дагуу иргэнд үүсгэж байгаа цаг хугацааны болон мөнгөн зардлыг байж болох хэмжээнд гэж үзлээ.

Хуулийн этгээд буюу хуулийн төслийн тухайд Монголын хуульчдын холбоонд ямар нэг шинэ төрлийн зардал үүсэхгүй бөгөөд харин ч зардал ачаалал одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиас багасахаар байгааг онцолж байна. Учир нь Монголын хуульчдын холбоо нь зарим чиг үүргээ гүйцэтгэхээ больж, бусад хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллагад тухайн чиг үүрэг шилжсэн байгаатай холбоотой юм.

Иймд хуулийн төсөл нь хуулийн этгээд, төрд зардал үүсгэхгүй боловч үр өгөөжийн хувьд эерэг үр дагавар үүсгэхээр байна.

-----oOo-----

## АГУУЛГА

### НЭГ.ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛТГААНЫ ТАЛААР

#### ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

#### ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

- 3.1."Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт
- 3.2."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт
- 3.3."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт
- 3.4."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

#### ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАН ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

- 4.1."Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
- 4.2."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
- 4.3."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
- 4.4."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

#### ТАВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ